

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-12
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	13-37
1.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/	16-18
2.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/	18-19
3.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/	19-21
4.Байнгын хорооны даргыг сонгох тухай	21-31
5.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	31-37

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 05-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 50.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 29 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Баатархүү, Р.Батболд, Ж.Батжаргал, Х.Баттулга, Б.Батцэцэг, П.Батчимэг, Ж.Баярмаа, Ж.Баясгалан, Д.Бум-Очир, Ш.Бямбасүрэн, С.Бямбацогт, А.Ганбаатар, Д.Ганбат, Г.Дамдинням, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалан, Б.Заяабал, Ч.Лодойсамбуу, С.Лүндэг, Л.Мөнхбаясгалан, Г.Очирбат, Л.Соронзонболд, Р.Сэддорж, А.Ундраа, Ч.Ундрэм, О.Цогтгэрэл, С.Цэнгүүн, Б.Энхбаяр, Д.Энхтуяа, С.Эрдэнэболд;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, О.Батнайрамдал, Х.Жангабыл, М.Нарантуяа-Нара, Н.Номтойбаяр, Л.Энх-Амгалан, Д.Энхтүвшин, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Б.Баярбаатар, Х.Болормаа, Ж.Галбадрах, Л.Гантөмөр, Г.Лувсанжамц, Ц.Туваан, Б.Тулга;

Тасалсан: Т.Аубакир, Х.Булгантуяа, Д.Жаргалсайхан, С.Замира, З.Мэндсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Энхбаяр;

Хоцорсон: Ч.Анар -31 минут, Б.Батбаатар -34 минут, Д.Батбаяр -03 минут, Э.Болормаа -1 цаг 23 минут, Т.Доржханд -03 минут, Б.Жавхлан -08 минут, Б.Пунсалмаа -15 минут, Р.Эрдэнэбүрэн -02 минут.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдээ татан авах тухай албан бичгийг 2025.12.04-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцов./

Нэг.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа нар байлцав.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Н.Учрал: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Р.Сэддорж, У.Отгонбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан урьдчилсан мэдээ, Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын энэ хуулийн 6.1-д заасан хугацаанаас өмнө гаргасан статистикийн мэдээллийг үндэслэн даатгагч энэ хуулийн 4.1.8-д заасан гэрээний хугацаанд нөхөн төлбөрийг нэг удаа урьдчилан олгож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 19
Бүгд: 67
71.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 7.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 15
Бүгд: 67
77.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “хуулийн” гэсний дараа “7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “зургаан” гэснийг “таван” гэж,” нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 15
Бүгд: 67
77.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 17
Бүгд: 67
74.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 15

Бүгд: 67
77.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Н.Учрал: Ажлын хэсгийн гаргасан, Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 16
Бүгд: 67
76.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцов.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр нар байлцав.

Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Н.Учрал: 1.Байнгын хорооны саналаар Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 19
Бүгд: 68

72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, С.Одонтуяа нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Байнгын хорооны саналаар Гэр бүлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 16
Бүгд: 68

76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 17
Бүгд: 68

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих боломжгүй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 63
Бүгд: 68

7.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

5.Байнгын хорооны саналаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 19
Бүгд: 68

72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 18
Бүгд: 68

73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 15

Бүгд: 68

77.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 17

Бүгд: 68

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Байнгын хорооны саналаар Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих боломжгүй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 64

Бүгд: 68

5.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

10.Байнгын хорооны саналаар Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 15

Бүгд: 69

78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Байнгын хорооны саналаар Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 15

Бүгд: 69

73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр нар байлцав.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Н.Учрал: 1.Байнгын хорооны саналаар Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 18
Бүгд: 69
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Байнгын хорооны саналаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 16
Бүгд: 69
76.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 78.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 20
Бүгд: 69
71.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 17
Бүгд: 69
75.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 16
Бүгд: 69
76.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 20
Бүгд: 69
71.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 16
Бүгд: 69
76.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Байнгын хорооны саналаар Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 16
Бүгд: 69
76.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 78.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Байнгын хорооны саналаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 16
Бүгд: 69
76.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Байнгын хорооны саналаар Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 17
Бүгд: 69
75.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Байнгын хорооны саналаар Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 15
Бүгд: 69
78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Байнгын хорооны саналаар Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 17
Бүгд: 69
75.4 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Байнгын хорооны саналаар “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 15
Бүгд: 69
78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга

Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Ц.Мөнхбат, Р.Эрдэнэбүрэн, Г.Ганбаатар, Ц.Сандаг-Очир, Ж.Батсуурь, Б.Бейсен, Ц.Даваасүрэн, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Н.Учрал: Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	44
Татгалзсан:	27
Бүгд:	71

62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэнгийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 63.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатарыг сонгохыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:30/

Уг асуудлыг 11 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Г.Ганбаатар, Б.Пунсалмаа нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас дэмжсэн санал:

Н.Учрал: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн 5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 46
Бүгд: 72
36.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, С.Ганбаатар, Ц.Идэрбат нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 40.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн нэрийг “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах” Монгол Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай” гэж, төслийн 2, 3, 4 дэх заалтын “Мөн тогтоолын” гэснийг “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 42
Бүгд: 72
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын “Эхлэл” сургуулийн 11А ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн урилгаар “UB Debate 2025 мэтгэлцээний хөтөлбөр”-ийн сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачилсан “Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн менежерүүдийг бэлтгэх хөтөлбөр”-ийн залуу эмч, мэргэжилтнүүд, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Г.Хосбаяр нарын урилгаар Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн урилгаар “Open parliament-Зүүн бүс оюутны дадлагажих хөтөлбөр”-ийн оюутнууд Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, Чуулганы хуралдааны хэлтсийн референт Б.Нарантуяа, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 26 минут үргэлжилж, 126 гишүүнээс 72 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр 11 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 29 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Цаг 10 цаг 10 минут, чуулганы хуралдаан бол 10 цагт эхлэх ёстой, 10 минут өнгөрөөд байна. Ирц 48 гишүүн ирцэд орсон, 38,1 хувийн ирцтэй байна. Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна. Гэр бүлийн хууль, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх процессын хууль, Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах санал хураалт. Чуулган санал хураалтаар эхэлнэ.

Сая өглөөний 9 цагт Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороон дээр энэ тэтгэврийн зээлтэй холбогдуулаад ирсэн өргөдөл гомдлыг хэлэлцсэнтэй холбогдуулаад Төв банк, мөн Хаан банк, Төрийн банкны удирдлагуудтай уулзлаа. Ингээд өнгөрсөн хугацаанд хийсэн судалгаа датад үндэслээд, тодорхой санал шийдлүүдийг Өргөдлийн байнгын хороон дээр бас Их Хурлын гишүүдийн тавьсан байр сууриудыг нэгтгэж ярилцлаа. Та бүхэн бол мэдэж байгаа. Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд энэ тэтгэврийн зээлийн хугацааг сунгах, зээлийн хүүг бууруулах чиглэлээр олон санал гомдлууд ирсэн.

Өргөдлийн байнгын хорооны зүгээс тодорхой гаргасан шийдлүүдийг надад нэгтгэж ирүүлсэн. Одоо энэ ахмадуудаас гэхэд гар утсанд бараг 7104 мессеж ирчхээд байна. Энэ чинь 3 өдрийн дотор. Тэгэхээр Улсын Их Хурлын зүгээс Монголбанкны хараат бус байдалд халдах, эсвэл бизнесийн зарчмаар үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкнуудад бодлого, чиглэл өгөх нь бидний бүрэн эрхэд хамаарах асуудал биш. Гэхдээ Улсын Их Хурал бол бага ард түмэн, ард түмний төлөөлөл. Ард түмний зүгээс, иргэдийн зүгээс гаргаж байгаа саналуудыг шийдлүүдийг нь гаргаж ярилцаж, шийдвэрлэх ийм үүрэгтэй.

Өнөөдрийн нөхцөл байдал сүүлийн тоогоор 2025 оны 10 сарын байдлаар тэтгэврийн зээлийн нийт үлдэгдэл 2,4 их наяд төгрөг байна. Тэтгэвэр авагчдын 56 хувь 294,4 мянган иргэн зээлтэй, 1 зээлдэгчийн дундаж зээлийн үлдэгдэл 8,1 сая төгрөг байна. Ахмадууд тэтгэврийн орлогынхоо 82,6 хувийг зээлийн төлбөрт өгч байгаа. Гэхдээ энэ тоо бол 2025 оны 7 сарын 7-нд өр, орлогын харьцааг нөгөө тогтоохгүйгээр нөгөө харьцааг нь авч хаяснаас өмнөх тоо юм байна. 7 сарын 7-ноос өр, орлогын харьцааг нь авч хаяснаас хойш 100 хувь тэтгэврийн зээл авч байна гэсэн үг. Нэг ёсондоо ахмадууд тэтгэврээ 100 хувь барьцаалж зээл аваад, ямар ч орлогогүйгээр амьдарч байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр бид энэ дээр томоохон бодлого гаргаж ажиллахгүй бол энэ механик шинж чанартай ийм арга хэмжээнүүдийг авлаа гээд тодорхой өөрчлөлтүүдийг гаргахгүй, гаргаж чадахгүй.

Тийм учраас энэ тэтгэврийн шинэчлэлийг хийх, энэ хагас хуримтлалтай тогтолцоонд шилжсэн энэ асуудлаа үргэлжлүүлэх, хувийн тэтгэврийн сан байгуулах, даатгалын салбараа бэхжүүлэх эрх зүйн орчин шинэчлэлийг хийхээс өөр бидэнд арга зам байхгүй гэдгийг ойлгох ёстой. Тэгээд маш энгийнээр хэлбэл

тэтгэврийн зээлийн хугацааг уян хатан болгох асуудалд анхаараач гэж иргэдийн зүгээс шаардлагуудыг тавьж байгаа юм. Жишээ нь сарын 800 мянган төгрөгийн тэтгэвэртэй хүн 8 сая төгрөгийн зээлийг жилийн 17,8 хувийн хүүтэй авахад жишээ нь зээлийн хугацаанаасаа хамаараад 24 сараар байна гэвэл сарын зээл хүүгийн төлбөр 399 мянга. Хэрвээ энийг 36 сар болгочихвол 288 мянга хүртэл буурчихна. Тэгэхээр 100 мянган төгрөгөөрөө тухайн ахмад нөгөө эмээ авах, нөгөө өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнээ авах бололцоо бүрдэнэ.

Тэгэхээр гол асуудал ерөөсөө л 18 хүртэлх сараар авсан байгаа ахмадуудын тэтгэврийн зээлийг 36 сар хүртэл хэрвээ сунгавал энд нөгөө сар болгон үүсэж байгаа ачаалал нь буурчихна, тэр 100 мянган төгрөгөөр жишээ нь. Энэ ачаалал буурчихвал түүнийгээ эм тарианд зарцуулах бололцоо бүрдэнэ л гэсэн үг. Тэгэхээр ийм л арга хэмжээг авах ёстой. Энэ ч утгаараа Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 12 сарын 11-ний өдөр хуралдаад, энэ санал шийдлүүдийг авч хэлэлцье гэдэг байр сууриа илэрхийллээ. Арилжааны банкнууд ч гэсэн саналаа илэрхийлсэн. Тэгэхээр үүн дээр Монголбанкнаас тэтгэврийн зээлийн эрсдэлийн жинг 150 хувь болгон тогтоосон байдаг нь энэ чанаргүй зээлтэй ижил түвшинд байгаа асуудлыг анхаарч харах, дээрээс нь заавал байлгах нөөц Монгол банкны Мөнгөний бодлогын хороогоор тэтгэврийн зээлийн үлдэгдэлтэй тэнцэхүйц хэмжээний эх үүсвэрийг чөлөөлөх боломжтой эсэх тухай энэ Өргөдлийн байнгын хорооноос гаргаад байгаа асуудлыг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хэрхэн авч шийдвэрлэх вэ гэдэг дээр тодорхой шийдвэр гаргаад явах нь зөв гэдгийг бид нээлттэй ярилцсан.

Тэгэхээр 12 сарын 11-ний өдөр Монголбанкны Мөнгөний бодлогын хороогоор одоо авчихсан байгаа ахмадуудын тэтгэврийн 18 хүртэлх сараар авчихсан байгаа тэтгэврийн зээлийн хугацаа 36 сар болчихвол сарын ачаалал буурчихна. Энэ сарын ачаалал буурчихвал түүнийг нь дахиж зээл авахад биш, нөгөө эм тариагаа авахад, нөгөө талх, сүүгээ авахдаа зарцуулах ийм л бодлогыг барья. Тэрнээс биш өр, орлогын харьцааг авлаа гээд 100 хувь тэтгэврээ барьцаалж зээл аваад, ямар ч орлогогүйгээр хүн амьдар гэдэг ийм шаардлага хүргүүлээд байна шүү дээ. Ингээд үр хүүхдүүд нь аав, ээжийнхээ гар утсыг бариад аппликэйшнээр зээл авдаг. Ингээд ахмадууд маань ямар ч орлогогүйгээр амьдрах ийм нөхцөл рүү л түлхээд байна.

Тийм учраас Их Хурал ч тэр, Засгийн газар ч тэр цаашдаа энэ тэтгэврийн шинэчлэл реформыг хийх ажил руу орно. Манай тэтгэврийн шинэчлэлийн ажлын хэсэг тухайн үед ажилласан. Ариунзаяа сайдын үед энэ хагас хуримтлал руу алхам хийсэн, одоо алхам хийсэн. Тэгээд Хувийн нэмэлт тэтгэврийн хууль орж ирсэн. Тухайн үед Байнгын хороон дээр буцчихсан. Одоо тэрнээс хойш хэдэн жил болж байна, 3 жил болж байна. 21 оны 10 сарын 4-нд байхгүй юу тэр Хувийн нэмэлт тэтгэврийн хууль анх хэлэлцээд, дараа нь Ариунзаяа сайдын үед Засгаас нэг барьсан юм. Тэгээд түүнээс хойш ингээд гацсан. Одоо Их Хурал дээр ажлын хэсгүүд байгуулна, зөвхөн энэ тэтгэврийн шинэчлэлээр шүү. Тэрнээс биш өөр асуудлаар биш. Тэр 58 хэрэгтэй, хэрэггүй ажлын хэсгүүдийг татан буулгасан. Одоо гол бодлогын 7 ажлын хэсэг, тэгээд 10-аас дээш том ажлын хэсэг огт байгуулагдахгүй.

Их Хуралд Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулиуд дээр чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгүүдийг тухайн цаг хугацаанд нь байгуулаад явна. Гэхдээ бидний 1 дүгээр асуудал бол даатгалын асуудал, энэ тэтгэврийн шинэчлэлийн асуудал, санхүүгийн салбараа дэмжих асуудал, энэ эдийн засгаа 2 тулгуурт болгохгүй бол нэг ийм банкны эдийн засагтай яваад байвал цаашаа ийм механик ийм косметик шинэчлэлүүд үр дүнд хүрэхгүй.

Юутай ч 12 сарын 11-нд Монголбанкны энэ Мөнгөний бодлогын хороо хуралдах юм байна. Түүн дээрээ даруй энэ асуудлуудыг шийдвэрлэе гэдэг саналыг хэлсэн. Ахмадууд энэ 18 сараар авчихсан байгаагаа 36 сар болговол сар болгон төлөх ачаалал буурна гэдэг ийм шийдвэрийг гаргана гэдэгт бид хэд итгэлтэй байгаа. Тийм учраас санхүүгийн мэргэжилтнүүдийн хийсэн шийдлүүдэд үндэслээд, тодорхой саналуудыг Монголбанк тэтгэврийн зээл олгож байгаа Хаан банк, Төрийн банкны удирдлагуудад уламжиллаа. Тэгээд хамтдаа ажиллах ёстой, шийдлээ гаргах ёстой гэдгийг Их Хурлын гишүүдэд хэлье.

Тэгээд D.parliament-аар ирсэн иргэдийн өргөдөл гомдлуудыг бид авч хэлэлцэн. D.parliament дээр 100 мянган хүний гарын үсэг цуглачихсан бол Их Хурал хэлэлцэнэ. Энэ чинь хуультай. Тэр үл хөдлөхийн татварын 2 хувийг ч гэсэн хэлэлцэнэ. Тэгээд 100 мянган хүн санал өгчихсөн байхад 100 мянган хүнийг загнаад байхгүй шүү Их Хурлын гишүүдэд анхааруулахад. 100 мянган хүн гарын үсгээ цуглуулаад өгчхөөд байхад түүнийг хэлэлцэх үүрэгтэй шүү Их Хурал. Тэрнээс биш ингээд 100 мянган хүнийг загнаад зандраад байж болохгүй шүү. Энэ чинь иргэд 100000-уулаа санал өгчхөөд байна шүү дээ. Хүн амьдарч байгаа 2 өрөө байраа 3 өрөө байр болгоё гээд зарахаараа түүнийгээ хувь хүний орлогын албан татварт 2 хувийг нь төлчихөөр тэр чинь орлого олох зорилготой биш шүү дээ. Тэр 2, 3, 4, 5 дугаар байр нь орлого олох зорилготой байдаг юм байгаа биз. Өөрийнхөө нэр дээр байгаа ганц байраа зарсныхаа төлөө орлогын албан татвар төлөөд байгаа шударга бус байна гэдгийг иргэд шүүмжилж байна. Тийм учраас энэ үл хөдлөх татварын 2 хувь дээр ажлын хэсгийг байгуулаад, Сайнзориг гишүүн ажиллаж байгаа гэж надад мэдээлэл өгсөн. Тэгээд түүнийг даруй хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Эхлэл” сургуулийн 11А-ийн ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ганбаатар гишүүнийхээ халуун дотно мэндчилгээг эрхэм багш, сурагчид та бүхэнд хүргэе. Сурлага хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсье. Ганбаатар гишүүн маань Баянгол дүүрэгтээ 3 дахь удаагаа сонгогдоод, хариуцлагатай, зарчимтай сайн ажиллаж байгаа шүү гэж ээж, аавдаа хэлээрэй гэж байгаа юм хамгийн сүүлд нь. Энэ сонсогдож байгаа биз дээ тийм ээ, яваагүй, чуулган эхлээгүй байгаа шүү дээ.

Гишүүдээ 47,6 хувийн ирцтэй байна. Ирц бүрдээд, шууд санал хураалт. Ирц бүрдээд, шууд санал хураалт эхэлнэ. Байнгын хороо хуралдаж байгаа юм уу? 49,2 хувийн ирцтэй байна. Бүлгийн бүлгийн дарга нар ирц бүрдүүлэе. Ариунзаяа дарга ирцээ бүрдүүлэе. Аюулгүй байдлын байнгын хороо хэлэлцүүлэг хийж байгаа тийм ээ, тэр хэлэлцүүлгээс 2 гишүүнийг дуудаарай.

Ирц 64 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 5 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Засгийн газар 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ. Зарчмын зөрүүтэй 6 саналаар санал хураана. Гишүүд дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ. 2 дугаарт, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Засгийн газар 11 дүгээр сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх үргэлжилнэ. 3 дугаарт, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна, хэлэлцэх эсэх үргэлжилнэ. 4 дүгээрт, Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэнэ. 5 дугаарт, Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна, Засгийн газар 2025 оны 11 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, зарчмын зөрөөтэй 2 санал байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1-д хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатад санаачилсан хуулийн төслөө татан авч болно гэж, 32.3-д хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатад байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хуулийн төсөл татан авах тухай Засгийн газрын 1/137 дугаартай албан бичиг ирүүлснийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Хуулийн төсөл татан авах тухай. Монгол Улсын Засгийн газраас Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнуудын хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дагалдуулан 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасны дагуу татан авч байгаагаа үүгээр мэдэгдэж байна. Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргалаа, хавсралт 1 хуудастай, Монгол Улсын Ерөнхий сайд гэсэн хуулийн төсөл татан авах бичгийг та бүхэнд танилцуулъя.

Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг татан авсанд тооцлоо. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 6 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай

намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан урьдчилсан мэдээ, Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын энэ хуулийн 6.1-д заасан хугацаанаас өмнө гаргасан статистикийн мэдээллийг үндэслэн даатгагч энэ хуулийн 4.1.8-д заасан гэрээний хугацаанд нөхөн төлбөрийг нэг удаа урьдчилан олгож болно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Идэрбат, Батжаргал, Ганбаатар, Сэддорж, Отгонбаяр цаашид ажлын хэсэг гэх. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 48 зөвшөөрч, 71,6 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 7.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 52 гишүүн дэмжиж, 77,6 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “хуулийн” гэсний дараа “7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “зургаан” гэснийг “таван” гэж,” нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 52 гишүүн дэмжиж, 77,6 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн. 50 гишүүн дэмжиж, 74,6 хувиар санал дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 52 гишүүн дэмжиж, 77,6 хувиар санал дэмжигдлээ. Гишүүдэд баярлалаа.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжсэн санал. 1.Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Идэрбат, Батжаргал, Ганбаатар, Сэддорж, Отгонбаяр. Санал хураалт. Гишүүдийн 51 нь дэмжиж, 76,1 хувиар санал дэмжигдлээ.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийг дагаж өргөн мэдүүлсэн Малчны хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах санал дэмжигдсэн тул Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналыг хуралдаанд оролцсон

гишүүдийн олонх дэмжсэн тул Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоолыг баталсанд тооцлоо.

Мэндчилгээ танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалангийн урилгаар “UB Debate 2025” мэтгэлцээний хөтөлбөрийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлага хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

10.38 цаг

Хоёр.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

2 дахь асуудалдаа оръё. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэнэ. Хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар Гэр бүлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 49 гишүүн дэмжиж, 72,1 хувиар санал дэмжигдлээ. Хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явагдаж дэмжсэнээр тооцож байна. Ганбаатар гишүүн, Одонтуяа гишүүн нарыг дэмжсэнээр протоколд тэмдэглэлд үлдээе.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдээр санал хураалт явуулна. Гэр бүлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 52 гишүүн дэмжиж, 76,5 хувиар санал дэмжигдлээ.

3.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 51 гишүүн дэмжиж, 75 хувиар санал дэмжигдлээ. 3.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг, Иргэний хуульд.

Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулах нь байна шүү. Байнгын хороо дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 5 гишүүн дэмжиж, 7,4 хувиар санал дэмжигдсэнгүй.

5.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 49 гишүүн дэмжиж, 72,1 хувиар санал дэмжигдлээ.

6.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 50 гишүүн дэмжиж, 73,5 хувиар санал дэмжигдлээ.

7.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 53 гишүүн дэмжиж, 77,9 хувиар санал дэмжигдлээ.

8.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 51 гишүүн дэмжиж, 75 хувиар санал дэмжигдлээ.

9.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 4 гишүүн дэмжиж, 5,9 хувиар санал дэмжигдсэнгүй.

10.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 54 гишүүн дэмжиж, 78,3 хувиар санал дэмжигдлээ.

11.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 51 гишүүн дэмжиж, 73,9 хувиар санал дэмжигдлээ. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлье.

10.44 цаг

Гурав.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Дараагийн асуудалд оръё. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 51 гишүүн дэмжиж, 73,9 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдээр санал хураана. 2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 53 гишүүн дэмжиж, 76,8 хувиар санал дэмжигдлээ. Дамдины Цогтбаатар гишүүнийг дэмжсэнээр протоколд үлдээе.

3.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 49 гишүүн дэмжиж, 71 хувиар санал дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 52 гишүүн дэмжиж, 75,4 хувиар санал дэмжигдлээ.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Санал хураалт. 53 гишүүн дэмжиж, 76,8 хувиар санал дэмжигдлээ.

6.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 49 гишүүн дэмжиж, 71 хувиар санал дэмжигдлээ.

7.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 53 гишүүн дэмжиж, 76,8 хувиар санал дэмжигдлээ.

8.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 53 гишүүн дэмжиж, 76,8 хувиар санал дэмжигдлээ. Баасанжаргал гишүүнийг дэмжсэнээр протоколд үлдээе.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 53 гишүүн дэмжиж, 76,8 хувиар санал дэмжигдлээ.

Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 52 гишүүн дэмжиж, 75,4 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Тогтмолын Мөнхсайханы санаачилсан эрүүл мэндийн салбарын эмнэлгийн менежерүүдийг бэлтгэх хөтөлбөрийн залуу эмч, мэргэжилтнүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 54 гишүүн дэмжиж, 78,3 хувиар санал дэмжигдлээ.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 52 гишүүн дэмжиж, 75,4 хувиар санал дэмжигдлээ.

“Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 54 гишүүн дэмжиж, 78,3 хувиар санал дэмжигдлээ. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ. Баярлалаа.

10.51 цаг

Дөрөв.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Дараагийн асуудалдаа оръё. Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэнэ. Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Мөнхсоёл: Үүрийнтуяа гишүүн унших байсан юм, тэгээд намайг уншчихаач гээд өглөө хэлсэн юм. Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Төсвийн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд, дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Төсвийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэгт Байнгын хорооны даргыг сонгохдоо Улсын Их Хуралд сонгогдсон, ажилласан хугацаа, туршлагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээс сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно гэж заасны дагуу Төсвийн байнгын хорооны даргад Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатарын нэрийг дэвшүүлсэн болно.

Нанзадын Наранбаатар нь 1974 онд төрсөн, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1992 онд Өмнөговь аймгийн 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, 1996 онд Цэргийн их сургууль, 2011 онд Америкийн Нэгдсэн Улсын Калифорнийн олон улсын их сургуулийг тус тус төгссөн. Эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй. Наранбаатар нь 1996-аас 1998 онд Цэргийн их сургуульд багш, 1998-аас 2002 онд Төрийн өмчийн хороонд мэргэжилтэн, 2002-оос 2004 онд Өмнөговь аймгийн Татварын хэлтсийн дарга, 2004-өөс 2009 онд Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, 2011-ээс 2015 онд Билэгт Говь компанийн гүйцэтгэх захирал, 2016-аас 2020 онд Өмнөговь аймгийн Засаг дарга, 2020 оноос эхлэн Улсын Их Хурлын гишүүнээр 2 дахь удаагаа сонгогдон ажиллаж байгаа бөгөөд Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн болно.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, цаашид Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэхдээ жендерийн тэгш байдлыг харгалзаж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг дэмждэг байх, Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа Засгийн газрын тусгай сангууд болон төсвийн гүйцэтгэлийн талаар төрийн аудитын байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт, Улсын Их Хурлаар тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа Төрийн мөнгөний бодлого болон төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхэд хэрхэн анхаарах, мөн Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшигчийн боловсрол, ажлын туршлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байхад анхаарч, төсвийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй талаар санал хэлж, Төрийн мөнгөний бодлого болон Бүгд найрамдах Солонгос улсын экспорт, импорт банкны шугамаар хэрэгжүүлж байгаа 10 аймгийн төвийн дулааны станц барих төслийн хэрэгжилт, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьчлал, Төрийн банкны удирдлагатай холбоотой асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа илэрхийлж, тус Байнгын хорооны дарга нь эдийн засаг, төсөв, санхүүгийн чиглэлээр мэргэшсэн байх, мөн төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж, төсвийн бүтцийг оновчтой болгоход анхаарч ажиллах нь зүйтэй талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, 2026 онд иргэдийн төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хугацааг хойшлуулсан талаар тайлбар хэлж, Төсвийн байнгын хорооны даргын үүргийг гүйцэтгэх хугацаанд хамтран ажилласан Байнгын хорооны гишүүддээ талархсанаа илэрхийллээ.

Төсвийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатарыг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Мөнхсоёл гишүүнд баярлалаа. Нэр дэвшигч Нанзадын Наранбаатараас асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Мөнхбат, Золжаргал гишүүнээр тасаллаа. Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Золжаргал: Наранбаатар гишүүнд амжилт хүсье. Төсвийн материал авахад ойлгогддоггүй, задаргаа нь байдаггүй гээд зургийг сканердсан байдаг гэж их хэл ам хийсээр байгаад одоо овоо pdf ирдэг болсон. Гэхдээ хавсралт хүснэгтүүд дээр нийлүүлээд тоо бодох гэхээр хуулж болдоггүй, нэгтгэж болдоггүй, заавал Сангийн яам руу тусдаа хүсэлт явуулж, араас нь нэхэл дагуул болж байж авдаг ийм зүйл байгаа. Та үүн дээр анхаарч өгөөрэй. Төсөв, тооцоо материалаа Засгийн газраас ирүүлэхдээ тэр задаргаатай тооцоо хийж болохоор форматаар авдаг байхыг нь шахаж шаардаж өгөөрэй гэж хүсье. Өөр юмгүй, баярлалаа.

Н.Учрал: Наранбаатар гишүүн, Наранбаатар гишүүн хариулах уу? Санал гэж ойлголоо. Санал уу? Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн.

Ц.Мөнхбат: Наранбаатар гишүүнийгээ Төсвийн байнгын хорооны дарга болж байгаад их баяртай байна. Манай говийн бүс нутгаас сонгогдсон гишүүн. Бид жил болгон төсөв дээр энэ бүс нутгийн хөрөнгө оруулалттай холбоотой асуудлуудыг ярьдаг төсөв яригдах болгонд. Тэгээд манай говийн бүс нутгаас Монгол Улсын эдийн засгийн нэлээдгүй дийлэнх хэсгийг нь ер нь бүрдүүлдэг хэр нь бүс нутгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын асуудал маш дутуу дулимаг байдаг, хангалтгүй байдаг талаар бид өөрснөө ч зөндөө олон удаа ярьж байлаа. Манай тойрогт ажиллаад явж байхад манай Өмнөговь, Дундговь, энэ Дорноговь гээд говийн бүсийн аймгуудын иргэд маань их хэлэх юм. Тэгэхээр зэрэг манай Наранбаатар гишүүн өөрөө аймаг орон нутаг удирдаж байсан, хөдөөгийн нөхцөл байдал, зовлон жаргалыг мэддэг хүн. Тэгээд Төсвийн байнгын хорооны дарга болж байна. Энэ ирэх онд хийгдэх энэ хөрөнгө оруулалтуудтай холбоотой, төсвийн энэ бодлоготой холбоотой юмнууд дээр нэлээн сайн ажиллах байх гэж их итгэж найдаж байна.

Наранбаатар гишүүндээ амжилт хүсье. Бүгдээрээ энэ төсвийн бодлогыг зөв болгох, Төсвийн тухай хуульд тодорхой өөрсдийн байр суурь, санал бодлоо сайн илэрхийлж явах энэ зүйлүүд дээр таныг маш их санаачилгатай ажиллана гэж ингэж бодож дэмжиж байгаа юм. Танд ажлын амжилт хүсье.

Н.Учрал: Санал хэллээ. Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууна.

Р.Эрдэнэбүрэн: Өглөөний мэнд хүргэе. Наранбаатар гишүүнийг Төсвийн байнгын хороон даргаар томилогдож байгаад баяртай байгаа, амжилт хүсье. Жил болгон маргаан гарч байгаа энэ говийн бүсээс авч байгаа тэр Амнатын татвар өнөө бүсэд хуваарилагдаж байгаа татварыг хуу хамаад авчихдаг, орон нутагт үлдэх мөнгийг өгдөггүй энэ тэр гээд энэ маргаанууд байдаг. Тэгээд энийг шийдэх тийм боломж гарч ирж байгаа байх гэж ингэж бодож байна.

2 дугаарт одоо бид хэд нэг зоригтой, зоригтой алхмууд хийж явахгүй бол нөгөө аргацаасан байдалтай ингээд яваад сая ингээд 2, 3 сар ерөөсөө ямар ч хууль реформ юм ярьсангүй, томилгоо явсаар байгаад ингээд дууслаа. Тэгээд он гараад нэг жоохон идэвхтэй болмоор байх юм. Уул уурхайн сайд зөвхөн нэг бензин колонкуудын энд бензин ирж байгаа, тэнд бензин ирж байгаа гэсэн л хүн боллоо. Энэ нефтийнхээ үнийг чөлөөлье зоригтой, бензин тос нөгөө цаг хугацаа зааж байгаад. Оруулж ирэх чадах нь оруулж ир гээд ингээд чөлөөлчихмөөр байх юм. Энэ

дээр Байнгын хорооны дарга, Төсвийн байнгын хорооны дарга шахаж өгөх ёстой байх гэж ингэж бодож байна.

Ялангуяа энэ говийн юутай бүстэй холбоотой Оюу толгойн асуудлаар ингээд бөөн маргаан болж байгаа. Их Хурлын даргад ч гэсэн хэлмээр байгаа юм. Энэ Засгийн газрын Хэрэг эрхлэхийн дарга болохлоор Оюу толгойтой яг хэлэлцээр явж байна энэ үед ийм Оюу толгойн нөгөө хэлэлцүүлэг болох гээд байна гээд ингээд яриад байдаг. Тэгэхлээр энийг энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөл эд нар дээр ярьж байгаад шийдэж болдоггүй юм уу? Үнэхээр тийм байгаа бол нэг бол та захирамж гаргаад тэр Оюу толгойн хэлэлцүүлгийг хойшлуулж барьдаг ч юм уу, эсвэл Засгийн газрынхаа хэлэлцээрийг өөрчлөх ч юм уу ингээд нэг жоохон бодлоготой баймаар юм шиг байх юм. Их Хурал дээр нэг өөр юм яриад, Засаг нь өөр юм яриад ингээд яваад байж болмооргүй байх юм энэ олонх. Шинээр томилогдож байгаа Төсвийн байнгын хороон дарга иймэрхүү энэ бодлогын юмнууд руу нэлээн орж өгмөөр байна.

Дээр нь энэ Хэмнэлтийн хуулийг больё одоо. Хэмнэлтийн хууль бол энэ хөрөнгө оруулалтуудыг хэнийх нь хөрөнгө оруулалтуудыг явуулах вэ, хэнийх нь хөрөнгө оруулалтыг явуулахгүй вэ гэдэг юмыг л шийддэг ийм хууль болж таарсан. Зарим хөрөнгө оруулалтуудыг нь харж байгаад л баахан юм хэлж гацааж байгаад Хэмнэлтийн хуулийн дагуу ингээд зогсоолоо гэдэг ийм болсон.

4-д нь энэ орон нутагт эрх өгөх ажлыг энэ төсвийн, төсөвтэй холбоотой ажлыг анхаарч шууд Төсвийн байнгын хорооны дарга энэ Их Хурал дээр нэлээн юу.../минут дуусав/

Н.Учрал: Эрдэнэбүрэн гишүүн их чухал асуудлыг хөндөж байна шүү. Тэгээд Наранбаатар гишүүн анхаарна биз. Ялангуяа Төрийн хэмнэлтийн хуультай холбогдуулж санал, дүгнэлт боловсруулах хэрэгтэй байна. Мөн энэ Амнатыг орон нутагт нөлөөллийн бүсүүдэд хуваарилах асуудлыг шийдэх хэрэгтэй. Тэгж байж уул уурхайгаа дэмжих бодлого хэрэгжинэ. Өмнөговь, Дорноговь шиг татаасгүй аймгуудыг олон болгох хэрэгтэй. Тэгээд нөлөөллийн бүсүүд, газрын хэвлийн баялгаа ашиглуулж байгаа бол тухайн орон нутагт нь Амнатын хуваарилалт илүү хийгддэг шударга зарчим руу шилжих ёстой. Тийм учраас энэ асуудлыг анхаараач гэж. Тэгэхээр Төсвийн байнгын хороо эдгээр асуудал руу илүү анхаараарай гэдэг саналыг хэлмээр байна.

Мөн Оюу толгойн сонсголтой холбогдуулаад энэ бол Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулагдаад, сонсголоо тов зарлаад ингээд хуулиараа явж байгаа юм байна лээ. Одоо бол Засгийн газар дээр яг хэлэлцээр явагдаж байгаа. Зээлийн хүү бууруулах асуудлаар хөрөнгө оруулагч тал ч гэсэн харилцан ойлголцоод буулт хийгээд ажиллаж байгаа гэдэг мэдээллийг Ерөнхий сайд өгсөн. Дэвшлүүд гарч байгаа. Орон даяар ярьснаараа асуудлыг мухарлана гэж бол байхгүй. Гэхдээ Их Хурал Хянан шалгах түр хороо байгуулах эрх зүйн боломжтой учраас Түр хороогоо байгуулаад, сонсголоо хийгээд явж байгаа.

Тэгэхээр энэ сонсголд холбогдох албан тушаалтнууд оролцоод, тайлбараа өгөөд явах ёстой байх гэсэн ийм л байр суурьтай байна. Тэгэхээр сонсголд оролцохдоо гэрчээр дуудагдсан бол хариуцлагатай оролцоод, байр сууриа нэгтгээд ингээд явна гэж ойлгож байгаа. Ирэх нэг дэхэд эхэлнэ гэсэн мэдээлэл би авсан. Тэгэхдээ 300 хүн гэрчээр дуудагдсан гэсэн. Тэгэхээр шинэ оныг дамжуулаад Цагаан

сар хүртэл өдөр болгон нэг хүн 5-аас 10 минут ярихад тасралтгүй хуралдах ийм байдалтай байгаа. Тэгэхээр 300 хүнээс хэн нь ярьж, хэн нь сууж, хэн нь ард нь зогсож, хэн нь хөгжөөн дэмжих вэ гэдэг нь ойлгомжгүй ийм байдалтай сонсгол болох гээд байна. Тийм учраас сонсголд яг оролцох яг хэн, хэн, ямар, ямар албан тушаалтнууд үг хэлэхийг тодорхой болгох ёстой байх. Тэгээд үүн дээр зохион байгуулалт дээр нь Их Хурлын Тамгын газар туслалцаа дэмжлэг үзүүлж ажиллах хэрэгтэй.

Тэгээд энэ бол их тийм сенсациалж болох, эсвэл дутуу мэдээлэлтэйгээр хандаж болох сэдэв огт биш. Гуравдагч хөршийн хөрөнгө оруулалт, Дэлхий дахин харж байна. Энэ бол бидний улс төрждөг сэдэв биш. Тийм учраас аль, аль талаасаа ухаалгаар асуудалд хандах хэрэгтэй. Сонсголыг хүндэтгээд оролцох ёстой, албан тушаалтнууд оролцоно. Их Хурал хуулиа хэрэгжүүлнэ. Монголын ард түмний талд энэ Үндэсний баялгийн сангийн хуулиа хэрэгжүүлэх талдаа бол хатуу байр сууриа нэгтгэнэ. Тэгээд үүн дээр гишүүдийг анхааралтай, идэвхтэй оролцохыг урьж байна.

Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл, Хосбаяр нарын урилгаар Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Алтангэрэл, Хосбаяр гишүүд нарынхаа халуун дотно мэндчилгээг та бүхэндээ хүргэж, гэр бүл, үр хүүхдэд нь сайн сайхан бүхнийг хүсье. Манай гишүүд энэ Алтангэрэл гишүүн шиг ингээд зочдоо өөрөө дагуулж орж ирээд, хөтлөөд ингээд танилцуулдаг ийм сайн жишгийг Алтангэрэл гишүүн нэвтрүүлж байна. Тэгээд өөрөө маш, тийм иргэд сонгогчдоо хүндэтгэж байгаа нэг хэлбэр юм. Тэгэхдээ чуулгандаа суух ёстой шүү. Баярлалаа. Ганбаатар гишүүн санал хэлнэ.

Г.Ганбаатар: Үг байгаа юу тийм ээ, би санал хэлье. Наранбаатар гишүүндээ баяр хүргэе, амжилт хүсэж байна. Улсын Их Хурал гэдэг байгууллагын 2 үндсэн том зүйл нэг нь хууль батлах, нөгөө нь төсөв батлах. Тэгээд нөгөө Төсвийн байнгын хороонд өнгөрсөн хугацаанд нэг жил гаран ажиллалаа. 2, 3 зүйл дээр их анхаарвал зүгээр юм уу гэж. Бид энэ жилийн төсөв батлагдаж байгаа зүйлийг өөрсдөө бүгд л мэдэж байгаа. Ерөнхийдөө бид төсвийн урсгал зардал гэдэг юм бол маш их өндөр. Бидэнд хөрөнгө оруулалтын орон зай гэдэг юм байхгүй боллоо. Тийм учраас төсвийнхөө энэ урсгал зардлыг бууруулах тал дээр Төсвийн байнгын хороо хамгийн их анхаарч ажиллах шаардлагатай харагдаж байгаа. Тэгээд үүн дээр маш их анхаарч ажиллах шаардлага бий шүү гэдгийг хэлье.

2 дугаарт нь бид энэ төсвийн орлогын бүтэц, яах вэ яах бид ер нь нэг Сангийн яамнаас оруулж ирж байгаа тооныхоо хүрээнд л ингээд төсвөө яриад байх шиг байгаа юм. Өөр ямар орлогын эх үүсвэр, өөр ямар орлого шинээр яах вэ энэ дээр Төсвийн байнгын хороо өөрсдөө их санаачилгатай ажилламаар юм шиг санагдаж байсан 2 дахь зүйл нь.

3 дахь зүйл энэ Амнатаас болоод энэ баяжуулах үйлдвэрүүд маань ихэнх нь өрөнд ороод хаалгаа барьчихлаа. Энэ Амнаттай холбоотой асуудлыг бид Төсвийн байнгын хороо анхаарч ажиллах. Энэ 3 зүйлийг таныг шинэ Байнгын хорооны даргын хувьд, Төсвийн байнгын хорооны даргын хувьд их анхаарч ажиллаасай гэж хүсэж байна. Танд амжилт хүсье.

Н.Учрал: Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшиж байгаа Наранбаатар гишүүнээ дэмжиж байгаа. Төсвийн байнгын хорооны даргаар томилогдож байгаатай холбогдуулаад, сонгогдож байгаатай холбогдуулаад ирэх долоо хоногт яаралтай энэ Сангийн сайдын мэдээллийг сонсох хэрэгцээ шаардлага байна. Энэ улсын хэмжээнд энэ улсын төсвийн төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, төсөв, санхүү маш хүнд байдалд ороод байна. Өнөөдөр ер нь 12 сарын байдлаар, 11 сарын гүйцэтгэлээр энэ улсын төсвийн орлого ямар байгаа юм, гүйцэтгэл, зарлага ямар байгаа юм гэдгийг нэг сонсож мэдээлэл авч, Засгийн газар ер нь ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэж байгаа юм гэдэг мэдээлэл сонсохгүй бол орон нутгийн төрийн байгууллагуудын удирдлагуудаас маш их хэмжээний мессеж ирж байна.

Ерөөсөө энэ 10 сар, 11 сараас хойш ерөөсөө ингээд энэ төрийн байгууллагууд дээр цалингаас өөр гүйлгээ хийхгүй ийм болсон. Үйл ажиллагаа явуулахад маш хүнд болсон. Цалингаа ч бүрэн бүтэн тавьж чадахгүй байдал руу орчихоод байна. Урамшууллуудыг олгохгүй гээд ингээд мэдэгдэл ирчихсэн байна. Ийм хүнд байдал руу, энэ чинь ямар, төсөв ямар байдал руу орчихоод байгаа юм бэ гэдгийг энэ Их Хурлын гишүүд ер нь хэр мэдээлэлтэй байна вэ. Манай энэ сайд нар, сайд маань, салбарын сайд маань ингээд төсвөө батлуулаад л явсан, тэгээд л одоо болсон. Энэ хугацаанд бид 26 оны төсөв баталсан, он дуустал хугацаанд ер нь яаж амьдрах юм бэ, эдийн засаг чинь ямар байдал руу орж байгаа юм бэ энийг нэг Төсвийн байнгын хорооны дарга ирэх долоо хоногт өнөөдөр Даргын дэргэдэх зөвлөл хуралдана биз. Ирэх долоо хоногт Байнгын хороон дээрээ хэлэлцээд, мэдээлэл сонсоод, шаардлагатай бол Их Хурал дээр асуудлыг авч ирж хэлэлцэх, мэдээлэл сонсох хэрэгцээ шаардлага бодитоор үүсчихсэн байна.

Энийг ярихгүй бол өнөөдөр 25 оны төсвийн юу, тендер шалгарсан компаниуд гүйцэтгэлээ авч чадахгүй байдал руу орчихсон. Сангийн яаман дээр, Нийслэл дээр, аймаг дээр гүйцэтгэлээ нэхсэн компаниуд боож үхэх гэж байна. Төрийн байгууллагын удирдлагууд бас, эмнэлгүүд болохоор аймаг, сум, нийслэл, дүүргийн эмнэлгүүд, улсын эмнэлгүүд чинь эрүүл мэндийн санхүүжилт нь дутуу дулимаг байхгүй, төсөв санхүү байхгүй гэдгээр тусламж, үйлчилгээ доголдож эхэлж байна. Эм тарианы хүрэлцээ байхгүй байна. Сургуулиуд бүгд, цэцэрлэгүүд бүгд цалингаа гүйцэд тавьж чадахгүй, оны эцэс рүү бүгд өр авлагатай үүсгэж байна. Тэгсэн хэр нь төсөвтөө багтааж ажил гэдэг ийм чиглэлийг дээрээс нь өгөөд байдаг. Өр үүсгэж болохгүй шүү гэдэг үүрэг чиглэлийг дээрээс нь өгөөд байдаг. Үгүй ээ ингээд яаж ажиллах юм бэ, яаж өр үүсгэхгүй байх юм бэ? Татвар, нийгмийн даатгал дээр маш олон тэрбум төгрөгийн, сая төгрөгийн алдагдалтай өртэй болчихсон явж байна. Татварын байцаагчид томоохон аж ахуйн нэгжүүдийг олон үе шаттайгаар дарамталж, төсвийнхөө.../минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут өгье Сандаг-Очир гишүүнд.

Ц.Сандаг-Очир: Тийм учраас энэ асуудлыг Улсын Их Хурал онцгой анхааралдаа авч, Улсын Их Хурлын дарга энэ Засгийн газрын мэдээллийг, Сангийн сайдын мэдээллийг сонсож, Төсвийн байнгын хороо болоод чуулган дээрээ сонсож, анхаарал хандуулахгүй одоо бол ингээд бүгдээрээ шинэ жилээр уур амьсгалчихсан, их багагүй шинэ жил хийгээд эхэлчихсэн, ханиад томуу өчнөөн байж байдаг.

Гэтэл энэ төсөв санхүүгийн байдал чинь амаргүй болчихсон байна шүү. Энэ экспорт чинь үнэ чинь уначихлаа нүүрсний үнэ, тэгээд бид цаашдаа ер нь маш хүнд

байдал руу орж байгаа гэдгээ хаана хаанаа анхаарч, энийг мэдэрч байгаа бол, хөдөө орон нутагт тэр өчигдөр Алтангэрэл сайдын хэлээд байгаа бензин шатахууны асуудал чинь байсаар байна. Сумын төв рүү, аймгийн төв рүү орж ирж чадахгүй болчихоод байна. Орж ирсэн нь буцаж чадахгүй болчихоод байна. Үнэн шүү дээ. Тэгээд ямар арга хэмжээ авч байгаа гэдэг асуудлуудыг өнөөдөр ярихгүй бол маш хүнд болчихсон байна гэдгийг Төсвийн байнгын хорооны шинээр томилогдож байгаа дарга энэ дээр онцгой анхаарал хандуулж ажиллаарай гэдгийг хэлье.

Н.Учрал: Өнөөдрийн хуралдааны дараа Даргын зөвлөл хуралдана. Тэгээд Наранбаатар дарга, Сандаг-Очир дарга нар энэ Төсвийн байнгын хороон дээр төсвийн гүйцэтгэлийг сонсох, нөхцөл байдлын талаар Сангийн сайдын мэдээллийг сонсох, шаардлагатай бол тогтоол санаачлах дээр анхааръя, анхааръя. Энэ Сандаг-Очир гишүүний саналыг Даргын зөвлөл дээр ярья. Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Орон нутагт төсвийн ерөнхийлөн захирагч хийж байсан Наранбаатар дарга Төсвийн байнгын хорооны даргаар сонгогдож байгаад дэмжиж байна, бас нэлээд зүйлийг хүлээж байна гэж ингэж ойлгож байгаа юм. 1 дүгээр асуудал энэ төсвийн цаглаврыг нэг анхаарч үзээч. Энэ доод шатнаасаа дамжиж явж байгаад хамгийн сүүлд салбар яамнууд дээрээс Сангийн яам руу 7 сарын 25-нд мэдээгээ өгдөг. Ингээд 9 сарын 1-нд барьдаг. Яг наадам амралтын үеүд таардаг, бүх төрийн албан хаагчид амарчихсан байдаг. Ингээд 9 сарын 1-нд төсөв өргөн барихад үндсэндээ магадлалгүй, магадлалаа хийлгэж амжаагүй, аудитаар орж амжаагүй гэдэг юм уу, зураг хөрөг нь дутуу. Ингээд дараагийн төсвийн жилд төсөвт орох боломжоос хангагдаж чаддаггүй, энийг та нэг анхаарч үзээч гэж ингэж бодож байгаа юм.

Нөгөөд гэвэл ер нь улсын хэмжээнд байгаа энэ царцсан барилгуудыг нэг дуусгавал яасан юм бэ? Төсвийг 3 хувааж тавьдаг асуудал буруу байна. Яагаад вэ гэхлээр үндсэндээ энэ өртөг нэмэгдэж байгаа, дуусахгүй, чанаргүй барилга бол 3 хувааж тавьж байгаатай л. Нэг цэцэрлэг нэг эхлээд нэг жил..., хэдий чинээ удлаа л бол өртөг нэмэгдээд байгаа байхгүй юу. Тэгээд тэр хүмүүсийг буруутгах боломж байхгүй. 6 тэрбумын цэцэрлэгийг хоёр хоёроор нь тавьчихдаг, тэгээд эхнийхийгээ идэж уугаад тэр чинь цалин, өвөлжин манадаг, 3 жил нэг цэцэрлэгийг явна. Тэгэхэд чинь нэг жилд хэдэн мянган айлын орон сууц барьж байна шүү дээ хувийн хэвшлийнхэн. Ингэхэд нэг жижигхэн блок цэцэрлэгийг 3 жил барь гэдэг чинь өөрөө өртөг зардлаа асар ихээр нэмэгдүүл гэж байгаатай агаар нэгэн болоод байгаа юм гэдгийг анхаарч өгөөч гэж хэлэх гэсэн юм.

Дээр нь энэ уул уурхайн баялгийн тэгш хуваарилалт, энэ зарим аймгууд манайх эко аймаг, уул уурхайгүй аймаг энэ тэр гээд гангараад байх юм. Энийг болих хэрэгтэй шүү дээ. Ялангуяа төвийн аймгууд. Ингээд уул уурхайгаас орж байгаа нэг роялтиг болонгуут тэгш хувааж авдаг, төсвийн татаас болгоод авчихдаг. Үйлээ бараад хил гаальтай хэрүүл заргатай, газар нутгаа ухуулаад, бэлчээр аж ахуйгаа сүйтгүүлээд байгаа нь болонгуут хамаг татвараа өгчихдөг, төсөвт төвлөрүүлэн татаад буцаагаад тэгшитгэн хуваарилдаг. Жишээлбэл Архангай, Булган гээд төвийн аймгууд байдаг. Бид аялал жуулчлалын бүс нутаг, яадаг ийдэг уул уурхайгүй аймаг энэ тэр гээд. Яахлаараа тэгж болж байдаг юм. Тэгээд гол устай гээд. Харин ч харин гол усгүй газраа дэмжих ёстой юм биш үү эсрэгээрээ. Энэ байдлыг нэг анхаарч өгөөч гэсэн ийм зүйлийг танд хэлэх байна. Тэгээд ер нь төсвийг тодотгодог асуудал байна. Сая манай энэ Их Хурал.../минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут өгье Батсуурь гишүүнд.

Ж.Батсуурь: Өнгөрсөн 24 онд одоо бидний байгуулсан энэ Их Хурал бол орж ирээд төсөв тодотгосон. Дараа нь дараа жилийнхээ төсвийг ярьсан, төсвийн хориг ирээд дахиад төсвөө тодотгосон, дараа жилийнхээ төсвийг ярьсан ингээд 7, 8 удаа ч төсөв ярьчихав уу. Тэгээд ахиц дэвшил гарахгүй байна. Тийм учраас энэ асуудлыг би юу гэж хэлэх гэж байна вэ гэхлээр анхан шатнаас нь ерөөсөө тэр олон ажлын хэсэг гэдэг үг ч одоо моодноос гарах шиг л боллоо доо. Ер нь сум, багаас нь авхуулаад нэг шүүрдэж, ажлын хэсэг гарч энэ төсвөө нэг цэгцлээд, ингэж урсгал зардлыг танахгүй бол анхан шатад, дунд шатад учир нь мэдэгдэхгүй нэг малгай доор орж ирээд ингээд төсвийн урсгал зардал тэнд үр ашиггүй зарцуулагдаж байгаа асуудлууд зөндөө байж байгаа, зөндөө байж байгаа. Жишээлбэл 1 сум 2 соёлын төвтэй шинэ хуучин 2, 2 спорт заалтай шинэ.../минут дуусав/

Н.Учрал: Бейсен гишүүн.

Б.Бейсен: Төсвийн байнгын хорооны даргаар сонгогдож байгаа Наранбаатар гишүүндээ баяр хүргэж, дэмжиж байгаа гэдгээ хэлье. Энэ төсөвтэй холбоотой хэд хэдэн санал хэлье гэж бодож байна. Ялангуяа эрүүл мэндийн салбарын төсөв бол Эрүүл мэндийн даатгалын сан нь хоосорсон. Эмнэлэгт хэвтэж байгаа улсууд бүгд гаднаас эм авчирч байна. Дөнгөж сайд нь өгөөд, Сандаг-Очир гишүүний саналыг дэмжиж байна, үнэхээр цалин өгөөд л аргалж байна. Эрүүл мэндийн сайд чадлаараа ингээд ажиллаж байна, цаана нь төсөв нь байхгүй. Тийм учраас энийг дэмжихгүй бол үнэхээр болохгүй нь. Энэ дээр онцгой анхаарлаа хандуулаарай.

Нөгөө талаар жилийн жилд төсөвт юм тавигддаг 9 жил явж байгаа барилга байж байна. Ийм улсуудыг хар дансанд оруулаад, заримыг нь дахиж төсвийн хуваарилалт дээр юм анхааруулга өгөөд, хар дансанд оруулдаг юм тийм юмандаа анхаарахгүй болохгүй байна.

Бензин шатахууны асуудал дээр онцгой анхаарахгүй бол алслагдсан аймгууд дээр төсөв төвийн аймагтай адилхан байдаг хүрдэггүй ерөөсөө. Өлгийд 1500 хүрчихсэн байна шүү дээ бензин. Манай Жангабыл гишүүн түрүүн буулгачхаад ирлээ гэсэн буулгасан юм байхгүй юм байна. Ард иргэд бол бид нар руу дайрч байна худалч хулгайчууд гээд. Тийм учраас энэ дээр нэг нэлээн анхаарч ажиллахгүй бол алслагдсан аймгууд дээр онцгой анхаарахгүй бол болохгүй асуудал байж байна Байнгын хорооны даргаа.

Дараагийн нэг чухал асуудал энэ төсөв хуваарилуулахдаа төсөв, улсын төсвөөс, төрийн сангийн мөнгөнөөс хумсалдаг улсууд байж байна. Ногоон нуурт дөрөв, таван зуун сая гээд байсан балгас болсон барилга дөрөв, таван зуун сая ч хүрэхгүй, гурван зуун сая хүрвэл их юм. Сая тэрбум 408 саяар батлуулаад тийм юм авч байгаа юм. Энийг газар дээр нь очиж шалгах хэрэгтэй. Ийм юм төрдөө анхаарлаа хандуулдаггүй тийм төрөөс юм хумсалдаг улсуудыг хэн нь, ямар лоббигоор ийм юм хийдэг юм төсөв хүрэхгүй байхад. Ийм юман дээр онцгой анхаараад, хариуцлага тооцох тал дээр нь анхаарч ажиллаарай гэж хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Нэр аваад дууссан шүү. Түрүүн тэндээс дарагдаагүй гээд эхэлж хэлсэн. Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Наранбаатар гишүүнийг дэмжиж байгаа, аймаг орон нутагт ажиллаж байсан туршлагатай хүн. Ер нь ингээд хараад байхад нэг аймаг орон нутаг удирдаж байсан хүмүүс арай өөр юм, амьдралд наалдацтай юм ярих юм. Ажил, амьдралын туршлагагүй, нухлуулаагүй улсууд ер нь ирээдүйд учрах хүндрэл бэрхшээлийг төсөөлдөггүй ч юм байна, боддоггүй ч юм байна. Тэгээд л нэг сэдэв хайгаад л, нэг хууль нийгэмд таалагдсан юм ярьчихъя гээд л нэг иймэрхүү байдлаар яваад байдаг. Хуучин Их Хурал ямар байсан гэвэл яг өдийд төсвийн гүйцэтгэлийг бүүр шаардаж байгаад ярьдаг байсан юм. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл ямар байна гээд ингээд ярьдаг байсан, одоо огт ярихгүй, валютын нөөц ярьдаг байсан одоо ярихгүй, мөнгөний бодлогыг бид яаж хэлэлцэв ингэж болохгүй шүү дээ.

Тийм учраас жоохон хэдүүлээ жоохон амьдралд наалдацтай юм ярьдаг, попрехоо жоохон багасгаад, бодлого тодорхойлох, бүтээлч санаачилга гаргах гэсэн ийм чиглэл рүү явахгүй бол юу ч үйлдвэрлэдэггүй, ямар ч баялаг бүтээдэггүй энэ орон чинь байна шүү дээ одоо та нар төсвийн гүйцэтгэлээ хар 10 сарын байдлаар 3,1 их наядаар тасарчихсан явж байна.

Экспортын гол орлого нүүрс чинь өнгөрсөн жилтэй харьцуулахад 2,9 тэрбум доллароор тасарчихсан явж байна. Энэ чинь түймэр тавьчих гээд байна шүү дээ эдийн засагтаа. Бид санаа зовох ёстой шүү дээ, Их Хурал санаа зовох ёстой шүү дээ. Энд зүгээр нэг сэдэв хөөцөлдсөн юм яриад суугаад байх биш. Тийм учраас хэдүүлээ энэ нэг Монголбанкны Ерөнхийлөгч гэж бүүр орж ирэхээ ч больсон байна. Энэ нэг төсөв, эдийн засгийн байдлаа эд нарыг ер нь сонсож, ярьдаг байхгүй бол болохгүй. Ирэх хаврыг яах юм бэ, ирэх хаврын 1 дүгээр улиралд байна шүү дээ валют ордоггүй юм, бизнес явдаггүй юм. Энэ үед илүү төсвийн чинь байдал хүндэрнэ.

Мөнгөний нийлүүлэлт 21, 22 онтой, 22 онд 30 их наяд байсан, одоо 45 их наяд 50 хувиар өсчихсөн байна шүү дээ мөнгө. Тэгэхээр 1 долларт ноогдох мөнгө мөнгөний хэмжээ 50 хувь өссөн байна. Бид одоо жоохон алдвал 5 мянга руу доллар явна. Энэ мэт асуудлаа бид ярихгүй бол болохгүй. Их Хурал чинь Монголбанкийг хянаж байгаа гол байгууллага нь шүү дээ. Монголбанк чинь манай харьяа. Тийм учраас энэ төсөв, төсөв бол Улсын Их Хурлын гол асуудал. Тэгээд энэ зүйлүүд дээрээ хэдүүлээ нэг оны төгсгөлд сайн яриад, ирэх жилээ яаж харах юм бэ, эхний улирлаа яаж авч явах юм бэ гэдэг юмнуудаа нэг жоохон анхааралтай хандахгүй бол эдийн засгийн нөхцөл байдал маш хүнд болсон байна гэдгийг хэдүүлээ нэг жоохон ойлгох цаг болоод байх шиг байна гэдгийг хэлье. Тэгээд Наранбаатар дарга хүнд үед гарч байна, тэгээд анхаарч ажиллана биз.

Н.Учрал: Баасанжаргал гишүүнд үг өгье.

Х.Баасанжаргал: Дандаа эрчүүд хэллээ шүү дээ. Яах вэ нөгөө Байнгын хорооны даргын асуудлыг сонгох шийдвэрлэх асуудал манай Бүлгийн эрх мэдлийн эрх хэмжээний асуудал байгаа. Гэхдээ бас би Бүлэгтээ зориулаад энэ үгийг хэлэх ёстой гэж бодож байгаа. Их Хурал өөрөө жендерийн эрх тэгш байдлыг хангаж байх ёстой. Би Байнгын хорооны даргыг эмэгтэй хүн болох болов уу, тэр дундаа Үүрийнтуяа гишүүнийг болох болов уу гэсэн хүлээлттэй байсан. Харамсалтай нь ийм өөр шийдвэр гарлаа. Тэгэхдээ энэ бол Наранбаатар гишүүний буруу биш, манай Бүлэг бас энэ асуудал дээр цаашид анхаарах ёстой гэж бодож байгаа. Их Хурал өөрөө хүний эрх, жендерийн талаарх өөрийн гэсэн үнэлгээ хийж байсан. Энэ

үнэлгээ дээрээ бид ахиц дэвшил гаргах ёстой манай энэ удаагийн парламент. Тэгэхээр энэ үнэлгээгээ ер нь бид байнга харж байх ёстой байх гээд нэг ийм агуулга.

2 дугаарт төсөв хэлэлцэх процесс буюу ялангуяа Их Хурал дээр ирсэн хойно энэ төсөв ерөөсөө нээлттэй байхгүй байгаа. Ажлын хэсгээс ямар санал гарсан юм, гишүүд санал өгөхөөсөө өмнө танилцах энэ процесс бүгд хаалттай, бүгд ерөөсөө маш шахуу хугацаанд ширээн дээрээ суусан үед энэ нөгөө зарчмын зөрүүтэй 143 санал жишээ нь өнгөрсөн хугацаанд тараагдсан. Тэгэхээр төсөв ийм байдлаар дараагийн удаа хэлэлцмээргүй байна. Тэгэхээр Байнгын хороо энэ төсөв хэлэлцэх процессыг нээлттэй, ил тод болгох, ялангуяа яг Байнгын хороо, яг ажлын хэсгийн хэлэлцэж байгаа энэ процессуудыг ямар саналууд гарч байгаа юм, юун дээр гишүүд санал өгөх юм гэдэг энэ процессууд нээлттэй, ил тод, гишүүд өөрсдөө уншиж танилцах боломжтой ийм цаг хугацаатай байх ёстой. Өмнөх төслийн хэлэлцүүлгийг бодвол энэ удаагийн төслийн хэлэлцүүлэг уг нь бол хангалттай хугацаа байсан шүү дээ. Тэгтэл бид яаж хандлаа гэсэн үг.

3 дугаарт манай тойргийн гишүүд төсөв баталсны дараа бүгдээрээ ийм матрын нулимс унагаагаад, дандаа худлаа, худлаа юм ярьцгаах юм. Яг төсөв батлах үеэр та нар бүгдээрээ тойргийнхоо замыг яриад л явж байдаг биз дээ. Тэгээд дараа нь яг ингээд худлаа лаг, лаг юм яриад, би бүүр ингээд та нарыг хараад ингээд гайхаад байна. Ямар сайндаа эргэн тойрныхоо гишүүд энэ хүн чинь төсөв дээр ийм юм ярьж байсан хүн одоо болохоор өөр юм яриад байх юм гээд өөртөө ч заримдаа эргэлзэх юм та нарыг харахаар. Тэгээд нэгэнт макро түвшний юм, макро түвшний асуудлаа шийдэх гэж байгаа бол тэрэн дээрээ тууштай байгаач. Тэгэхээр цаашид төсвийн эрх мэдлийг орон нутаг руу шилжүүлэх асуудлыг дорвитой бодлогын хувьд яримаар байна. Яг нэг ийм нэг ийм тойрогтоо хуваадаг нэг ийм төсвийн бодлогоор цаашид бид угаасаа удаан явахгүй. Орон нутаг нь ч хөгжихгүй, хэдэн улс төрчид өөрсдийнхөө тойргийг усалдаг усалгааны систем болгочихсон шүү дээ энэ төсвийг. Тэгэхээр энийг өөрчлөх ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа. Тэгээд цаашид Төсвийн байнгын хороо энэ дээр Сангийн яамыг шахаж, бодлогын өөрчлөлтийг оруулж ирээрэй гэж хүсэж байна. Хэрвээ энийг оруулж ирэхгүй бол өөрчлөх эрх нь бидэнд байгаа биз дээ тийм ээ даргыг. Ийм үг хэлье.

Н.Учрал: Нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж дууслаа. Гишүүд байна уу, гишүүдийг танхимд урьж байна. Байнгын хорооны саналаар санал хураалтыг явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Төсвийн байнгын хороон дээр сая Даваасүрэн гишүүний хэлсэн саналаар энэ төсвийн гүйцэтгэлийг сонсох ёстой шүү. Тэгээд Даваасүрэн гишүүн та энэ ажлыг анхаараад, ахлаад энэ төсвийн гүйцэтгэлийг сонсмоор байна. Аймаг, орон нутгаас маш олон саналууд ирж байгаа тийм биз? Сангийн яамны бодит мэдээллийг сонсохгүй бол бид энд бүх юм болоод байгаа юм шиг суугаад байж болохгүй шүү. Валютын нөөцөө сонсьё. Ер нь одоо ингээд сонсох ёстой. Тийм учраас Наранбаатар дарга ирэх долоо хоногт хэлэлцэх асуудалд энэ асуудлуудаа оруулаад, ажилдаа шуурхайлан орно гэж бодож байна.

Тэгээд гишүүд та бүхэнд нэг зүйлийг хэлэхэд энэ Монголбанк, энэ Санхүүгийн зохицуулах хорооны 2 орон тооны гишүүн, тэгээд нэлээн олон албан тушаалтнуудын нөгөө хуулийн хугацаа дуусчхаад байгаа юм байна лээ. Хуулийн хугацаа нь дуусчхаад байгаа юм байна лээ. Тэгээд жишээ нь Наранбаатар гишүүн гэхэд Төсвийн байнгын хорооны дарга Шадар сайдаар томилогдчихсон, ингээд даргагүй энэ Байнгын хороо яваад байсан. Тэгээд биднийг нэг тийм томилгоо хийж байна гээд байдаг. Энэ чинь дарга байхгүй, тэгээд хуулийн хугацаа нь дуусчихсан

учраас дараа дараагийн хүмүүсийг нь томилоод, ажилд нь оруулаад явахаас өөр ийм хуулийн хугацаа байхгүй байгаа юм шүү. Тэрийг ойлгохыг хүсье. Нанзадын Наранбаатар гишүүн бол аймаг, орон нутаг удирдаж байсан хүн учраас Төсвийн байнгын хороон дээр илүү амьдрал руу орж ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатарыг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 44 гишүүн дэмжиж, 62 хувиар санал дэмжигдлээ. Эрдэнэбүрэн гишүүн дэмжсэн байна, дэмжсэнээр протоколд үлдээе. Байнгын хорооны даргаар сонгох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны даргаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатарыг сонгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэж. Нанзадын Наранбаатар даргад ажлын амжилт хүсье. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.30 цаг

Тав. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд оръё. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай танилцуулна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн танилцуулна. Индэрт урья.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн. Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж

ахуйн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 02, 04-ний өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа тогтоолын төслийг боловсруулахдаа хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг хангасан эсэх, мөн Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтын 11 дэх бүлгийн 11.1, 11.2 дугаар зүйлд заасан үндэсний квотыг, үндэсний кодыг тогтоолын төсөлд хэрхэн томъёолсныг тодруулж, төсөлд албан татварын хөнгөлөлт үзүүлэх барааны үндэсний кодыг нарийн зохицуулаагүйгээс үүдэн тогтоолыг хэрэгжүүлэхэд ойлгомжгүй байдал үүсэх эсэх талаар хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Д.Үүрийнтуяа нараас тогтоолын төсөлд найруулгын шинжтэй санал болон уг тогтоолын хэрэгжих хугацааг ердийн журмаар мөрдөх талаар санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хороодын санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарсан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Ажлын хэсгийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах дарга Даваасүрэнгийн Довчинсүрэн, Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Чойдоржийн Чимгэрэл гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулж намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан нэрсээ ирүүлсэн, нэрсээ ирүүлсэн гишүүд асуулт асууна. Рэгдэл гишүүн байхгүй байна. Сайнзориг гишүүн байхгүй байна. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Миний асуулт аягүй тодорхой. Татварын хэмжээг ингээд 5 хүртэл, 15 хүртэл гээд өөрөөр хэлбэл 5, 15 гэсэн энэ татварын хэмжээний ард хүртэл гэдэг хэмжээ заагаад орж ирж байна. Тэгэхээр 1 байх юм уу, 2 байх юм уу гэдгийг хэн шийдэх юм, ямар үзүүлэлтийг харгалзаж шийдэх юм бэ 1 дүгээр асуулт?

2 дугаарт, яагаад заавал баруун бүсээр юм бэ, бусад бүсэд иргэд амьдардаггүй юм уу, бусад бүсэд малчид байхгүй юм уу? Яагаад заавал зөвхөн

баруун бүсээр орж ирэх гурил, будаа, малын тэжээлийн татварын хэмжээг ингэж бууруулж байгаа юм бэ гэдэг ийм асуулт?

3 дугаарт, ингээд бид ийм бодлогын хувьд ерөөсөө тогтвортой байдал байхгүй байна. Сайд нь Хөдөө аж ахуйн өмнөх сайд энэ хаваржингаа эргэж энэ татвар тэглэсэн асуудлыг хүчингүй болгоё гэж явсаар байгаад Их Хурлаар оруулж ирээд татвар тэглэснийг хүчингүй болгуулсан. Одоо тэгсэн чинь буцаагаад татварыг бууруулна гээд ингээд л ороод ирэх юм, эргээд татвартай гээд. Тэгэхээр татварт, энэ татварын бодлого ерөөсөө урт хугацаандаа тогтвортой явахгүй байгаад байна л даа. Тэгэхээр нөгөө газар тариалангийнхан чинь бизнесээ төлөвлөж чадахгүй байгаад байна. Тэгэхээр энэ хууль өөрөө ямар хугацаанд үйлчлэх юм бэ, тэгээд дараагийн дунд хугацааны бодлого нь байгаа юу? Тэгэхээр газар тариалан, малын тэжээл энэ болгон дээр барьж байгаа яг бодлого нь өөрөө татварын бодлого нь ямар хугацаатай, ямар үе шаттай явах юм бэ гэдгийг тодорхой танилцуулаад өгөөч?

Н.Учрал: Бадамсүрэн сайд хариулна.

М.Бадамсүрэн: Энэ Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолоор тогтоолын 4 дэх заалтаар холбогдох барааны гаалийн албан татварын хувь хэмжээг тухайн салбарын бүтээгдэхүүнийг онцлогийг харгалзан тогтоох эрхийг Монгол Улсын Засгийн газарт олгосугай гээд энэ олгосон заалт дээр энэ гурил болон зарим төрлийн тэжээлийг татварыг нь тогтоох эрхийг Засгийн газарт олгож байгаа. Өөрөөр хэлбэл уян хатан байх эрхийг олгож байгаа гэсэн үг. Тэгээд энэ дээр тэжээл 5 хувийн татвартай байдаг, тэгэхээр 5 хүртэл гэдэг нь 1, 2, 3, 4, тэг байж болно гээд. 15 хүртэл хувь гэдэг нь бас адилхан. Гэхдээ Засгийн газрын тогтоолын төслийг манай яамнаас төслөө бол боловсруулж байгаа. Улсын Их Хурал чуулганаар энэ тогтоолыг өөрчлөлт оруулахыг дэмжсэн тохиолдолд тэг байхаар тогтоох ийм саналыг Засгийн газарт манай яамнаас оруулна. Тэгээд Засгийн газар бол энэ дээр тогтооно.

Яагаад баруун бүс вэ гэж баруун бүсийн хувьд хэд хэдэн онцлогтой байгаа. 1 дүгээрт тэнд гурилын үйлдвэр огт байхгүй. Тариалангийн үйл ажиллагаа бараг явагддаггүй, өөрөө өндөрлөг бүс тариалангийн үйл ажиллагаанд нэлээн хүндрэлтэй байдаг, дээр нь алслагдмал. Тийм учраас олон жилийн дунджаар баруун бүсээр импортоор гурил хамгийн их орж ирдэг Баян-Өлгий, Увс аймгийн боомтуудаар. Тийм учраас баруун бүсэд энийг энэ онцлогийг харгалзаж тогтоох саналыг оруулж байгаа.

Гэхдээ энд Улсын Их Хурлын 67 гишүүн буюу Баян-Өлгий аймгаас сонгогдсон Жангабыл гишүүний бланкаар 67 гишүүн энэ саналыг анх Засгийн газарт ирүүлсэн. Үүний дагуу Засгийн газар энэ тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах энэ саналыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа гэдгийг хэлье. Татварын бодлого, тийм татварын бодлого тогтвортой байх ёстой гэж байгаа. Энэнтэй санал нэг байна. Гэхдээ энд баруун бүсийн хувьд онцлог байдлыг харгалзаж үзээд ингэж энэ удаад ингэж оруулж байгаа. Цаашдаа аль болох дотоодын үйлдвэрлэлээ хамгаалах бодлого байна гэж нэг хэсэг нь үздэг. Нэг хэсэг нь ард иргэд хямд үнэтэй гурил хэрэглэх ёстой гэж үздэг. Тэгэхээр энэ тогтоолыг хэрэгжүүлээд явах энэ явцад тодорхой хэмжээний энэний үр дүн зөв үү, буруу юу, яах ёстой вэ гэдэг зүйл харагдана гэж ингэж тооцож байгаа.

Н.Учрал: Баасанжаргал гишүүн тодруулна.

Х.Баасанжаргал: Манай Их Хурлын гишүүд ер нь нэг бид нэг хууль тогтоомжийг батлахдаа нэг ийм жаахан лоббины шинжтэй хууль тогтоомжууд дээр жаахан анхаармаар байна. Би бол энэ баруун зөвхөн энэ баруун бүсээр оруулж ирж байгаа, баруун бүсээр орж ирж байгаа энэ малын тэжээл, гурил дээр татварыг нь Засаг бол бүр тэг болгох гэж байгаа юм байна шүү дээ. Энэ дээр үнэндээ яг хувь хүний хувьд хардлага байгаа. Увс аймгийн Баруунтуруун сум гэж маш том газар тариалангийн бүс нутаг байгаа. Тэгээд тэнд газар тариалан эрхэлж байгаа иргэд, аж ахуйн нэгж ингээд энэ өвөл яах юм бэ, энэ жил яах юм бэ, цаашид яах юм бэ? Татвар нь ингээд тэг хэвээрээ байвал тэнд ер нь газар тариалан эрхлэх юм уу, эрхлэхгүй юм уу, тэнд зээл олгох юм уу, олгохгүй юм уу гээд ингээд тэр бүс нутагт байгаа аж ахуйн нэгжүүдийг маш хүнд байдалд оруулж байна. Тэгээд Хэрэг эрхлэхийн дарга нь өөрөө эсвэл баруун бүсийнх болохлоор ингээд ороод ирдэг юм уу, баруун бүсийн гишүүд олуулаа болохлоор ингээд ороод ирдэг юм уу? Тэгэхээр ийм тодорхойгүй, ийм нөхцөл байдал, ийм Засгийн газрын.../минут дуусав/

Н.Учрал: Санал хэллээ. Ганбаатар гишүүн асуулт асууна.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Энэ тогтоол ч зайлшгүй авч хэрэгжүүлэх л шаардлагатай болчхоод байна л даа. Энэ жилийн өвөлжилтийн нөхцөл байдал ч хүнд байна. Сая тэгэхдээ энэ баруун, Баасанжаргал гишүүн бас яагаад зөвхөн баруун аймаг гэж асуугаад байна. Ерөнхийдөө энэ нийт газар нутгийн чинь энэ өвөл ер нь нийт газар нутгийн ихэнх нь цасан бүрхүүлтэй, өвөлжилт хүндэрч байх шиг байна. Сая говийн бүсээс сонгогдсон гишүүд бид Дундговь аймгийн баруун 8 сумаар яваад ирлээ. Эрдэнэдалай, Адаацаг, Сайхан-Овоо гээд үндсэндээ 20-оос 30см цасан бүрхүүл тогтчихсон. Тэнд бол одоо өвөлжилт маш хүндэрчихсэн байна.

Тэгээд үүнтэй холбоотойгоор зөвхөн баруун аймаг гэхгүйгээр энэ тэжээл, энэ бусад зүйлс дээрээ энэ яам анхаарч ажиллахгүй бол болохгүй байх. Хамгийн гол зүйл энэ мал аж ахуйн салбараа энэ эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцөө нэмэгдүүлэх чиглэлээр яаралтай ер нь арга хэмжээ аваад ажиллахгүй бол энэ өвөл ч их хүнд боллоо. Өнгөрсөн зун нийт газар нутгаар зуншлага их тааруухан, бэлчээрийн болоод таримлын гарц их муу байсан. Үүнтэй холбоотойгоор яг нийт нэг өвөлдөө ийм байдал хүндэрсэн үед хэдэн хувь нь бид өөрсдөө дотоодоосоо хангах, хэдэн хувь нь импортоор хангах гэсэн тооцоо байна уу та бүхэнд? Тэр нэг тоог эхлээд нэг сонсодохъё гэж бодож байна.

Н.Учрал: Ажлын хэсгээс хариулъя. Болорчулуун дарга 4 дүгээр микрофон.

Ц.Болорчулуун: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Тэгэхээр 2025 оны ургацын нөхцөл байдал ер нь яг тариалангийн төв бүс нутаг гантай байсны улмаас тодорхой хэмжээгээр ургац алдсан. Бид улсын хэмжээнд нийтдээ 320 мянган тонн улаан буудай байж дотоодын хэрэгцээгээ 100 хувь хангах ёстой. Тэгээд энэ жилийн тухайд бид гурил үйлдвэрлэлд 270 мянган тонныг нийлүүлээ дотоодын үйлдвэрт. Тэгээд 60 гаруй хувиа дотоодын үйлдвэрлэлээс хангахаар, дээрээс нь дутагдаж байгаа буюу 150 мянган тонн хүнсний улаан буудайг импортоор авах Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн шийдвэр гаргаад, нэр бүхий 12 аж ахуйн нэгжүүдэд квотыг нь өгөөд, энэ аж ахуйн нэгжүүд оруулж байгаа.

Тэгэхээр гурилын нийт хэрэгцээ талдаа дотоодын ургац бөгөөд импорттойгоо нийлээд хангах ийм боломж нь бүрдэж байгаа. Зүгээр өнөөдрийн энэ тогтоол бол мэдээж баруун аймгуудын түрүүн хэлсэн, сайдын хэлсэнчлэн гурилын үйлдвэр байхгүй алслагдсан бүс нутаг, дээрээс нь энэ баруун аймгуудад энэ жилийн тухайд нэлээдгүй хэмжээний гантай байсны улмаас малчдыг энэ өвлийг даван туулах нөхцөл байдлыг нь бүрдүүлэх үүднээс малын тэжээл, тэжээлийн нэмэлт, тэгээд гурилыг оруулж ирэх ийм гишүүдийн ирсэн санал дээр үндэслэж энэ Их Хурлын тогтоолд Засагт эрхийг нь авах ийм шийдвэрийг гаргуулахаар өнөөдрийн хуралдаанд оруулж байгаа юм.

Тэжээлийн нөөцийг нь аваад үзвэл энэ жилийн тухайд баруун аймгууд гантай байсны улмаас хадлан байхгүй. Тэгэхдээ зүүн аймгуудаас нэлээдгүй хэмжээний өвс тэжээл хадланг зөөсөн байгаа. Энэ жилийн нэг онцлог нь гэвэл баруун аймгууд зуд болох нөхцөл байдлыг мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт дээр үндэслээд, нэлээдгүй хэмжээнд малаа эдийн засгийн эргэлтэд оруулсан. Тэгэхээр зүүн талаас явж байгаа машинууд буцах сөрөг тээвэр дээрээ мал нэлээд эдийн засгийн эргэлтэд оруулсан учраас энэ 2 талдаа өвс тэжээлээ бэлдэх, нөгөө талдаа малаа эдийн засгийн эргэлтэд оруулах ийм боломж нөхцөл нь бүрдсэн. Өнөөдрийн байдлаар Бүгд найрамдах Узбекистан улсад нийтдээ 70 гаруй мянган толгой хонь гарч байгаа. Энэ бол ихэвчлэн баруун аймгуудаас бэлтгэгдсэн байгаа. Тэгэхээр ямар ч байсан зүгээр аймаг, сумын аюулгүй нөөцөд бэлдэх өвснүүдээ 70 гаруй хувьтай, 80 орчим хувьтай аймаг сумд бол бэлдсэн байгаа.

Н.Учрал: Ганбаатар гишүүн тодруулна.

Г.Ганбаатар: Саяын Болорчулуун даргын хариулттай холбоотойгоор энэ Хөдөө аж ахуйн яамнаас, ялангуяа энэ сайдаас энэ хөдөө орон нутагт явж байхад зуд турхнаас гадна, нийгмийн даатгалын нөхөн олголт их ярьж байна Бадамсүрэн сайдаа. Малчид ноолуур, махны үеэрээ ядаж хувааж төлдөг байж болохгүй юу. Хавартаа нэг ноолуур орлоготой болсон үедээ ноолуурынхаа мөнгөөр, намартаа нэг жоохон мах борлуулсан үеэр нийгмийн даатгалаа нөхөн төлөлтийн асуудлууд. Уг нь энэ хууль нь 25 оны 01 сарын 01-нээс хэрэгжинэ гэсэн. Одоо болтол холбогдох журам нь гарахгүй, хэрэгжихгүй байна. Нөгөө талдаа энэ малчдаа нэг жоохон мөнгөтэй болох үед нь ингээд хуваагаад төлдөг нөхцөл байдлыг Хөдөө аж ахуйн яаманд хэлж уламжлаач гэснийг энэ далимд хэлье. Энэ асуултыг Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын иргэн танд дамжуулсан шүү гэдгийг хэлье, өндөр настан Лхагвасүрэн гэдэг хүн дамжуулсан.

Н.Учрал: Санал хэлсэн үү? Бадамсүрэн гишүүн хариулъя.

М.Бадамсүрэн: Малчдын улирлын чанартай орлоготой уялдуулж энэ төлөх асуудлыг судалж үзье гэдгийг гишүүнд хэлье.

2 дугаарт нь энэ тэр нөхөн төлүүлэхтэй холбоотой энэ асуудал Засгийн газрын тогтоол хараахан одоо гараагүй байгаа юм байна. Тэгээд энэ тогтоолыг гаргуулах талаар энэ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энийг хариуцаж байгаа. Гэхдээ энэ дээр хараахан гараагүй байгаа юм байна лээ. Энийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хувьд малчдын нийгмийн асуудал, малчдын хүүхэд, тэдний гэр бүлийн асуудалд анхаарал хандуулах үүрэгтэй учраас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтарч энэ асуудал дээр бид ажиллана. Тэгээд танд энэ зүйл дээр тодорхой хариултыг дараа нь хүргүүлье.

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэгийн урилгаар Openparliament-Зүүн бүс оюутны дадлагажих хөтөлбөрийн оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилт хүсье. Зүүн бүсийн гишүүд, Зүүн бүсийн гишүүдийн нэрийн өмнөөс та бүхэнд сурлага хөтөлбөрийн өндөр амжилтыг хүсье. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууна.

Б.Пунсалмаа. Сайн байцгаана уу, энэ өдрийн мэндийг хүргэе. 126 гишүүнтэй парламент Засгийн газрын гишүүд бид ер нь нэг зарчим дээрээ нэгдчихмээр байгаа юм. Энэ бол дотооддоо үйлдвэрлэж байгаа үндэсний үйлдвэрлэлийн салбаруудаа дэмжих тал дээр тарифаар хамгаалах, импортоос хамгаалах энэ тал дээр бид нэгдэх ёстой гэж харж байгаа. Энэ асуудлыг 1999 онд тухайн үеийн улс төрчид маш сайн ойлгоод Импортын барааны гаалийн албан татварын хуулийг баталсан байна. Ингэж үндэсний үйлдвэрлэлээ тухайн үед хамгаалъя гэж шийдэж байсан байна. Үүнээс хойш энэ хууль 17 удаа өөрчлөлт орсон байна шүү дээ. Тэгээд хамгийн сүүлийн өөрчлөлт нь болохлоор 2024 оны 4 сарын 19-нд өөрчлөлт орж ирээд ингээд гурилын татварыг тэглэсэн импортын татварыг нь.

Үр дүнд нь 9 үйлдвэр, гурил боловсруулах 9 үйлдвэр байсны хагас нь өнөөдөр ажиллагаагүй болчихлоо. 1 үйлдвэрт дунджаар 500-гаад хүн ажилладаг гэж үзэхэд хэчнээн мянган ажлын байр байхгүй болчхов. Би энэ тогтоолын төслийг дэмжиж гарын үсэг зурсан юм. Яагаад гэвэл энэ салбар чинь өөрөө уначихлаа. Нэг салбар ер нь нэг уналтад орсны дараа сэргэхэд 3-аас 4 жил болдог юм шүү. Тэнд маш их хүмүүсийн хүч хөдөлмөр байгаа. Нэг хүний нэг үйлдвэр босгох гээд зүтгэсэн хүний нэг насны амьдрал явж байгаа. Энийг бид ийм алхныхаа үзүүрээр ийм хурдан, хурдан шийддэг байж болохгүй.

Бид импортыг дэмжээд, нэг үндэсний үйлдвэрээ байхгүй болгоход, нэг салбарыг байхгүй болгоход тэнд Монгол хүүхдийн ам руу хоол халбагадах гэж байснаа л больж байгаа байхгүй юу. Тэнд Монгол хүүхдүүд өлсөж магадгүй. Тийм болохлоор бид энэ үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах тал дээр ажиллах хэрэгтэй байна. Дахиж энэ хуулийг ингэж ойр ойрхон өөрчлөөд баймааргүй байна гэсэн санал хүргүүлж байгаа юм. Баярлалаа.

Н.Учрал: Пунсалмаа гишүүн санал хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 2 санал байна. Гишүүдийг танхимд урья. Гишүүд танхимд ирье. Гишүүд танхимд ирье. Байнгын хорооны, хамтарсан Байнгын хороо хуралдсан Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хамтарсан хуралдаанаас 2 санал, зарчмын зөрүүтэй 2 санал Байнгын хорооноос дэмжигдсэн юм байна.

Их Хурлын гишүүд танхимд ирье, тэгээд нэр ус цоллоод эхлэх уг нь арай болоогүй л байна даа. Он гарч байгаад тэгмээр байна. Тийм, нэр ус цолломооргүй байна. Ер нь жоохон хариуцлагатай л баймаар байна. Энэ хуулийг уу? Шаардлагагүй бол тэгээд санал нь унаад л явна биз. Саналаа хураая. Санал хураалтад бэлтгэе. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан зарчмын зөрүүтэй саналын

томьёоллоор санал хураалт явуулна. Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас дэмжсэн санал.

1.Төслийн 5 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бейсен, Үүрийнтуяа. Санал хураалт. 26 гишүүн дэмжиж, 36,1 хувиар санал нь дэмжигдлээ. Ганбаатар гишүүн, Бейсен гишүүн нарыг дэмжсэнээр протоколд үлдээе, Идэрбат гишүүнийг протоколд үлдээе. 5 дахь заалтыг хасах гэсэн дэмжсэн санал дэмжигдсэнгүй. 2 дугаар санал. Найруулгын санал. Үгүй ээ тэгээд 78, 9-үүлээ барьсан юм бол энэ өөрөө хуулиа өөрсдөө батлаач. Тийм, дэмжихгүй бол байгаа Их Хурлын гишүүд дэмжихгүй гэж байна. Тэгээд та нар өөрсдөө энэ хуулиа тэгээд та нарын асуудал шүү дээ.

2.Найруулгын санал. Төслийн нэрийг “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай” гэж, төслийн 2, 3, 4 дэх заалтын “Мөн тогтоолын” гэснийг “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бейсен, Үүрийнтуяа. Санал хураалт. Дэмжигдээгүй учраас өргөн барьснаараа дэмжигдэж байна л гэсэн үг. Тийм биз Бадамсүрэн сайд? Өргөн барьснаараа л явж байна гэсэн үг шүү дээ. 30 гишүүн дэмжиж, 41,7 хувийн саналаар дэмжээгүй гэсэн үг. Зарчмын зөрүүтэй санал 2 санал байсан байна. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлье.

11.54 цаг

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Даргын зөвлөл үргэлжлүүлээд хуралдана.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА